



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 14

Сүхбаатар сум

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.5.3, 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 3.1, 3.2, 2020 оны 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, Ерөө сумын 1 дүгээр, Алтанбулаг сумын 3 дугаар, Зүүнбүрэн сумын 1 дүгээр, Цагааннуур сумын 1 дүгээр, Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Орхон сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Сонгон шалгаруулах комиссын дарга:

Д.Ёндонжамц -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Нарийн бичгийн дарга:

Б.Ариундэлгэр -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн мэргэжилтэн, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

А.Эрдэнэгэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн


Ч.Жаргалсайхан -Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Б.Саруултөгс -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн

2. Сонгон шалгаруулалтыг зарласан хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулан дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн

шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Ариундэлгэр/-д даалгасугай.

ДАРГА



Ө.СҮБДАА

УХЛ0115
16